



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.11.03 № 44

Ховд аймгийн Мянгад сумын нутаг
дахь газрын ховор элементийн
Халзан бүрэгтэйн орд газрын
талаар Асуулга тавих тухай

Мэргэжлийн Хяналтын байгууллага татан буугдаж төрийн хяналт шалгалтын чиг үүрэг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харьяанд ирсэн тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг танд хүргүүлж байна.

2022 оны байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт өндөр технологийн үндсэн түүхий эд болох газрын ховор элементийн ашиглалтын Лугийн гол, Мушгиа худаг, Халзан бүрэгтэй зэрэг нийт 12 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй хүчин төгөлдөр байна.

Эрдэмтдийн судалгаагаар газрын ховор элементийн эцсийн бүтээгдэхүүн гаргаж авахын тулд хүхрийн хүчлийн концентрацыг өндөр температурт шатаах технологийг ашигладаг тухай мэдээлэл байдаг.

Гэтэл нэг тонн газрын ховор элемент үйлдвэрлэхэд ойролцоогоор 10000 орчим шоо метр олон төрлийн хорт бодис агуулсан хаягдал хий ялгарахын зэрэгцээ 70-100 шоо метр хүчил агуулсан ус, нэг тонн гаруй цацраг идэвхт хаягдал тухайн орчинд үлдэж хоцордог байна. Энэ нь боловсруулах үйл явцын хувьд уул уурхайн ямар ч бүтээгдэхүүнээс илүү өндөр эрсдэлтэй, физик-химийн технологи шаарддаг салбар болох нь харагдаж байна.

Эдгээр ордуудын нэг бол Ховд аймгийн Мянгад сумын нутагт дэвсгэрт орших газрын ховор элементийн Халзан бүрэгтэйн орд юм. Бидэнд байгаа мэдээллээр Халзан бүрэгтэйн орд нь Se, Nb, La, Zr зэрэг газрын ховор элементүүд агуулсан 5 сая тонн хүдэр байгаа талаарх нөөцтэй мэдээлэл байна.

Газрын ховор элементийн Халзан бүрэгтэй ордын үйл ажиллагаа ил тод бус, хайгуул, судалгаа, хүдэр олборлолт, боловсруулалтаас үүсэх цацраг-идэвхт болон цацраг идэвхт бус химийн хог хаягдал, түүнийг аюулгүй тээвэрлэх, хадгалах дүрэм, журам чанд мөрдөн ажиллахгүй байж магадгүй талаар, мөн газар нутгийнхаа экологийн байдал, цацраг идэвхт бодис агуулсан хүдрийн олборлолтын улмаас үүсэж болзошгүй эрсдлийн талаар санал бодлоо илэрхийлсэн орон нутгийн иргэдийг лиценз

2022000192

эзэмшигч компанийн зүгээс хууль хүчний байгууллагад захиалга өгч иргэдийн эрх, эрх чөлөөг боомилсон аливаа асуудлыг хууль шүүхээр хүч түрэн шийдүүлэх иргэдийг мөрдөн шалгуулж байгаа тухай, орон нутгийн цагдаа хууль хяналтын байгууллага иргэдийг байцаах, торгох шийтгэх, иргэдийн хууль ёсны эрхийг хязгаарлах үйлдэл гаргаж байгаа гомдол мэдээлэл Ховд аймгийн иргэд, тэр дундаа Буянт, Мянгад сумын малчид удаа дараа Улсын Их Хурлын гишүүн миний нэр дээр ирүүлсээр байна.


Иймд дээрх асуудлуудтай холбогдуулан дараах асуулгыг танд хүргүүлж байна.

1. Халзан бүрэгтэйн ордын хүдрийн биетийн орчимд 3 ашиглалтын лиценз бүртгэлтэй хүчин төгөлдөр байна. Эдгээр 3 лиценз, тус бүр хэдэн гектар, нийт хэдэн гектар талбайг эзэлж байгаа талаар,
2. Халзан бүрэгтэй орд орчмын дээрх 3 талбайн лиценз эзэмшигч компани болон түүний эцсийн өмчлөгчийн дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд ил болгох талаар,
3. Дээрх 3 ордын ашиглалтын лиценз олгохын өмнө Мянгад сумын иргэдийн хурал, багийн Нийтийн Хурлаар дэмжигдсэн эсэх талаар,
4. Тус орд газар нь цэнгэг усны арвин нөөц бүхий Ховд гол, Хар ус нуурын ай сзв, эко системийн гол цэгүүд болох Хар ус нуураас 19 км, Ховд голоос 8км, Буянт голоос 20 км, тарвас тариалалтын талбайгаас 17 км, Мянгад сумын төвөөс 19 км, Буянт сумын төвөөс 25 км-т оршдог. Энэ нь хүн, мал амьтан, нүүдлийн шувууд, газар тариалангийн бүсийн биологийн олон янз байдал, эко системийг алдагдуулах, сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэйг тооцож үзсэн эсэх талаар,
5. Газрын ховор элементийн эцсийн бүтээгдэхүүн гаргаж авах үйлдвэр барих эсэх талаар,
6. Хэрэв газрын ховор элементийн эцсийн бүтээгдэхүүн гаргаж авах үйлдвэр барих тохиолдолд хүдрийн олборлолт боловсруулалтаас үүсэх Хүхрийн хүчлийн хог хаягдлын менежмент хэрхэн хийх талаар,
7. Засгийн газраас тус ордын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгжийн ажилд аудит хийж болох эсэх талаар,
8. Хүн ам, гадаад орчны цацрагийн шарлагын тун Халзан бүрэгтэй ордын орчимд стандартаас илүү байгаа тухай иргэдийн мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан эсэх талаар,

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ш.АДЬШАА

2022000102